

ТЭЭВЭР, 2020 оны эхний улиралд

Агаарын тээвэр



	2019 I-III	2020* I-III	
Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	300.3	214.6	
Тээсэн ачаа, тонн	1 267.4	967.5	
Тээврийн орлого, сая төгрөг	92 594.6	51 842.2	

Төмөр замын тээвэр



Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	562.6	447.0	
Тээсэн ачаа, мян.тонн	6 582.1	7 089.4	
Тээврийн орлого, сая төгрөг	162 672.8	174 087.9	

Авто замын тээвэр



Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	41 618.7	28 462.2	
Тээсэн ачаа, мян.тонн	8 780.7	3 140.5	
Тээврийн орлого, сая төгрөг	160 920.9	85 931.9	

*-Урьдчилсан гүйцэтгэлээр



ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний улиралд 10.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1 (33.4%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.6 (64.2%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2020 оны эхний улиралд 29.1 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.4 (31.4%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 13.2 (31.6%) сая хүнээр буурсан нь нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2017 I-III	2018 I-III	2019 I-III	2020* I-III
Тээсэн ачаа, сая тонн	12.3	13.4	15.4	10.2
Зорчигчид, сая хүн	45.2	47.3	42.5	29.1
Тээврийн орлого, тэрбум төгрөг	291.8	357.6	416.2	311.9

Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа өмнөх улирлаас 7.9 (43.6%) сая тонн, зорчигчид 12.6 (30.2%) сая хүнээр тус тус буурсан байна.

Бүх төрлийн тээврийн орлого 2020 оны эхний улиралд 311.9 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 104.3 (25.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Авто тээврийн орлого 75.0 (46.6%) тэрбум төгрөг, агаарын тээврийн орлого 40.8 (44.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь бүх төрлийн тээврийн орлого буурахад нөлөөлсөн байна. Мөн бүх төрлийн тээврийн орлого өмнөх улирлаас 185.3 (37.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

АВТО ЗАМЫН ТЭЭВЭР

Авто тээврээр 2020 оны эхний улиралд 3.1 сая тонн ачаа, давхардсан тоогоор 28.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 5.6 (64.2%) сая тонн, зорчигчид 13.2 (31.6%) сая хүнээр тус тус буурсан байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр 5.4 сая тонн буюу 68.4 хувиар, зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 12.9 (33.7%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна. Мөн авто замын тээврээр тээсэн ачаа өмнөх улирлаас 7.3 (70.0%) сая тонн, зорчигчид 12.1 (29.8%) сая хүнээр тус тус буурсан байна.

Авто тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2017 I-III	2018 I-III	2019 I-III	2020* I-III
Тээсэн ачаа, сая тонн	7.5	7.3	8.8	3.1
Уул уурхайн бүтээгдэхүүн	6.7	6.5	7.9	2.5
Зорчигчид, сая хүн	44.3	46.4	41.6	28.5
Нийслэлийн нийтийн тээвэр	40.8	42.8	38.3	25.4
Тээврийн орлого, тэрбум төгрөг	119.4	135.8	160.9	85.9


Авто тээврийн салбарын орлого 2020 оны эхний улиралд 85.9 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 75.0 (46.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 138.3 (61.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Энд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2020 оны эхний улиралд 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 507.3 (7.7%) мянган тонноор өсжээ.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 714.3 (30.0%) мянган тонн, импортын ачаа 6.8 (1.1%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2020 оны 3 дугаар сард 2.4 сая тонн болж, өмнөх сараас 69.1 (3.0%) мянган тонноор өсжээ.

Төмөр замаар тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020* I-III
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	92.5	90.4	92.6
Барилгын материал	2.5	3.8	2.5
Мод, модон материал	0.5	0.4	0.4
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	0.8	0.8
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	0.5	1.7	0.8
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	0.4	0.9	1.3
Бусад	2.7	2.0	1.6

Төмөр замын тээврээр 2020 оны эхний улиралд тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 92.6 хувь, барилгын материал 2.5 хувь, хар төмөр 1.3 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 0.8 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.8 хувь, мод модон материал 0.4 хувь болон бусад бүтээгдэхүүн 1.6 хувийг эзэлж байна.

Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр 2020 оны эхний улиралд 447.0 (давхардсан тоо) мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 115.6 (20.5%) мянган хүнээр буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо буурахад орон нутгийн зорчигчид 108.4 (19.9%) мянган хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны 3 дугаар сард 101.2 мянган хүн болсон нь өмнөх сараас 2.7 (2.6%) мянган хүнээр буурчээ.


Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний улиралд 174.1 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 11.4 (7.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны 3 дугаар сард өмнөх сараас 6.0 (11.3%) тэрбум төгрөгөөр өсөж 59.0 тэрбум төгрөг болжээ.

АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2020 оны эхний улиралд 967.5 тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 300.0 (23.7%) тонноор буурсан байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар




Агаарын тээврээр 2020 оны эхний улиралд дотоодод 19.7 (2.0%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 1.0 (5.1%) тонноор өссөн байна.

Харин олон улсад тээсэн ачаа 947.8 (98.0%) тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 300.9 (24.1%) тонноор буурчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 3 дугаар сард 59.0 тонн болж, өмнөх сараас 396.6 (87.1%) тонноор буурсан байна.

Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний улиралд давхардсан тоогоор 214.6 мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 85.7 (28.5%) мянган хүнээр буурсан байна. Агаарын тээврээр 2020 оны 3 дугаар сард өмнөх сараас 34.8 (51.9%) мянган хүнээр бага буюу 32.2 мянган хүн зорчсон байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2020 оны эхний улиралд 84.3 (39.3%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 11.5 (12.0%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Оюутолгой чиглэлийн зорчигчид 13.2 хувь, Чойбалсан чиглэлийн зорчигчид 67.0 хувь, Улаангом чиглэлийн зорчигчид 25.2 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний улиралд 130.3 (60.7%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 74.2 (36.3%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад УлаанбаатарБээжин чиглэлийн зорчигчид 67.3 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 52.8 хувь, Улаанбаатар-Бангкок чиглэлийн зорчигчид 45.8 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 54.1 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 45.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны 3 дугаар сард өмнөх сараас 9.4 (39.6%) тэрбум төгрөгөөр буурч 6.2 тэрбум төгрөг болсон байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний улиралд 51.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 40.8 (44.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.